



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН  
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр  
Хурал болсон газар: Гадаад харилцааны яам

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 6 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-ийн Удирдах Зөвлөлийн шинэ гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэж, усны салбарын ТББ-уудыг төлөөлж ажиллах ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Геологи, гидрогеологийн салбарын зөвлөх профессор Н.Батсүх, Сайн засаглал, хариуцлагатай байдлын чиглэлээр ажилладаг ТББ-уудыг төлөөлж ажиллах Зориг сангийн Гүйцэтгэх захирал Б.Цолмон нарыг Удирдах зөвлөлийн шинэ гишүүдээр санал нэгтгэйгээр батлав.
2. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргыг томилох асуудлыг хэлэлцэж, Монголын МСС-ийн Хуулийн ерөнхий зөвлөх П.Баярыг Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргаар санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэлтэй гишүүд танилцаж, санал нэгтгэйгээр батлав.
4. Монголын МСС-ийн 2019 оны гуравдугаар улирлын санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг хэлэлцсэний дараа Монголын МСС-ийн 2019 оны гуравдугаар улирлын санхүүжилтийн төлөвлөгөөг санал нэгтгэйгээр баталж, МСК-д уламжлахаар шийдвэрлэв.
5. Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн хөрөнгөөр 2019.07.01-нээс 2020.06.30-ны хооронд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцсэний үндсэн дээр Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
6. Компакт гэрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2019.07.01-нээс 2020.06.30-ны хооронд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал нэгтгэйгээр батлав.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН